



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/397

Улаанбаатар хот

Г “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-ын
данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1105 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 703 000 /долоон зуун гурван мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий ГК6-817 маркийн 43-61 СЧ улсын дугаартай тээврийн хэрэгслийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ /Ц.Төрхүү/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ /Ц.Төрхүү/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /М.Мандах/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115050001145